

## Төсөлд тавигдах шаардлага

НБМУТП т ирүүлэх төсөл нь:

1.1 Нийслэлийн засаг даргын 2013 оны А69 тоот захирамжаар батлагдсан НБМУТ паркийн ТЭЗҮ, болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан паркийн хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу импортыг орлож экспортыг дэмжсэн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий барилгын материалын үйлдвэрлэлийн дагуу төсөл байх шаардлагатай.

1.2 Уг төсөлд худалдаа үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдсэн байна.

2. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана

2.1.төслийн товч агуулга;

2.2.иргэн, хуулийн этгээдийн нэр;

2.3.үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй хаяг байршил, иргэн, хуулийн этгээдийн албан ёсны хаяг, төсөл хэрэгжих байршил;

2.4.нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнээс өөрийн оруулах хөрөнгийн хэмжээ;

2.5.үйлчилгээ, үйлдвэрлэл болон худалдах бүтээгдэхүүний нэр, төрөл;

2.6.жилийн эргэлт, борлуулалт, экспортод эзлэх хувь;

2.7.одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл.

3. Үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагааны талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

3.1.үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн ажиллагаа;

3.2.туүхий эдийн чанарын үзүүлэлт;

3.3.туүхий эдийн нөөц;

3.4.үйлдвэрлэлийн хүчин чадал.

4. Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана:

4.1.удирдлагын бүтэц, орон тоо;

4.2.ажиллагдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар;

4.3.шинээр бий болгох ажлын байрны тоо.

5. Зах зээлийн судалгаанд дараах мэдээллийг тусгана:

5.1.зах зээлийн төлөв байдал /SWOT шинжилгээ/;

5.2.хэрэглэгчдийн тодорхойлолт.

6. Эдийн засгийн тооцоонд дараах мэдээллийг тусгана:

6.1.ундсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний нийт орлого;

6.2.борлуулалтын орлогын тооцоо;

- 6.3. үйлдвэрлэлийн зардлын тооцоо;
  - 6.4. бүтээгдэхүүний өргийн тооцоо;
  - 6.5. төлөвлөж байгаа борлуулалтын төлөвлөгөө;
  - 6.6. үйлдвэр, үйлчилгээ, худалдааны үр ашгийн тооцоо;
  - 6.7. төслийн өгөөж, өргийн тооцоо;
  - 6.8. төслийн эрсдэлийн удирдлагын тооцоо, даатгалд хамрагдах тооцоо;
  - 6.9. байгаль орчинд ээлтэй болон хор хөнөөлгүй, үйлдвэрлэл явуулах тооцоо
7. Дүгнэлтэд энэ журмын 4-6-д заасан тооцоо судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.

8. Төсөлд дараах материалыг хавсаргана:

- 8.1. иргэний баримт бичгийн хуулбар,
- 8.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 8.3. тоног төхөөрөмжийн жагсаалт, зураг;
- 8.4. үйлдвэрлэх болон худалдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, зураг;

Боловсруулсан  
Инженер

Хянасан  
Дарга

Б. Батбилэг

С. Батжаргал

